



I-IX/2021

Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



## Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сард 17.2 хувиар буурлаа

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөг болж, 3.1 (97.3%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 87.1 (2.7%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.


ХҮСНЭГТ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021* I-IX	<u>2021* I-IX</u> <u>2020 I-IX</u>
	тэрбум төгрөг				хувь
<b>Нийт</b>	<b>3 458.6</b>	<b>3 929.4</b>	<b>3 898.6</b>	<b>3 229.7</b>	<b>82.8</b>
Дотоодын байгууллага	2 881.0	3 667.9	3 813.5	3 142.6	82.4
Төрийн	44.9	89.8	371.8	253.4	68.1
Хувийн	2 813.7	3 558.5	3 381.8	2 855.3	84.4
Гадаадтай хамтарсан	22.4	19.6	59.8	33.9	56.7
Гадаадын байгууллага	577.6	261.5	85.1	87.1	102.3

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 668.9 (17.2%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 670.9 (17.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлөв.

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 526.5 (15.6%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 253.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 118.5 (31.9%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагын барилга угсралт, их засварын ажил 33.9 тэрбум төгрөг болж, 25.9 (43.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Энэ оны эхний 9 сарын байдлаар барилга угсралт, их засварын ажлын 33.8 хувийг орон сууцны бус барилга, 32.8 хувийг орон сууцны барилга, 30.9 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.5 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 2.6 нэгж хувиар өссөн бол орон сууцны бус барилгын эзлэх хувь 1.7 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 0.5 нэгж хувиар, их засварын ажлынх 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

## ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021* I-IX	<u>2021* I-IX</u> 2020 I-IX
	тэрбум төгрөг				хувь
<b>Орон сууцны бус барилга</b>	<b>1 181.1</b>	<b>1 805.4</b>	<b>1 383.9</b>	<b>1 090.6</b>	<b>78.8</b>
Үйлдвэрийн	574.5	937.3	534.2	564.3	105.6
Худалдаа, үйлчилгээний	179.6	104.8	94.2	78.8	83.7
Эмнэлгийн	87.1	102.0	64.1	44.2	68.9
Сургууль, соёлын	183.2	420.4	422.4	255.7	60.5
Бусад	156.7	240.9	269.0	147.6	54.9

Орон сууцны бус барилгын ажлын гүйцэтгэл 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 293.4 (21.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, сургууль, соёлын барилгынх 166.7 (39.5%) тэрбум төгрөгөөр, бусад барилгынх 121.4 (45.1%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 20.0 (31.1%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 15.4 (16.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

## ЗУРАГ 2. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Улаанбаатар хотод 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 37.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 4.2 нэгж хувиар буурсан.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 964.3 тэрбум төгрөг, Дорноговь

аймагт 272.2 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 63.3 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт төмөр замын болон газрын тосны үйлдвэрийг дагасан барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.

## Ойлголт, тодорхойлолт

- Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.
- Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.
- Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.
- Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.

**Тайлбар:** ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл



### Эх үүсвэр:

ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

### Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга  
А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө  
аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн  
статистикийн хэлтсийн статистикч  
Х.Тэмүүлэн  
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212